



ДОРНОД АЙМГИЙН ЧОЙБАЛСАН СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
СОНГУУЛЬД ОРОЛЦОХ ЧОЙБАЛСАН
СУМЫН МОНГОЛ АРДЫН НАМД

ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

21000, Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2020.08.13 № 502

танай _____-ны № _____-т

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд орон нутгийн хурлын сонгуульд оролцох Чойбалсан сумын Монгол ардын намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох Чойбалсан сумын Монгол ардын нам нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль болон "Алсын хараа-2050"-д нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох Чойбалсан сумын Монгол ардын намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817 - 6 : 2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817 - 8 : 2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2020-2022 оны төсвийн төсөөллийн тухай хууль болон "Алсын хараа-2050", холбогдох бусад байгууллагаас авсан мэдээллийг шалгуур болгосон.

Дүгнэлт

"Чойбалсан сумын Монгол ардын нам"-ын сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, "Алсын хараа-2050", Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

"Чойбалсан сумын Монгол ардын нам"-ын мөрийн хөтөлбөр /.....хуудас/-ийг хавсаргав.

Хувийг: /Аймгийн/ Сонгуулийн хороонд
Хавсралт хуудаатай.

ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР БОЛОРТУУЛ



011020547

Дорнод аймгийн Чойбалсан сумын
Монгол Ардын Намын хорооны
2020 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн
Хуралдааны 04 тоот тогтоолын хавсралт



**ДОРНОД АЙМГИЙН ЧОЙБАЛСАН СУМЫН
МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРООНЫ 2020 ОНЫ
СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
СОНГУУЛЬД ОРОЛЦОХ МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

ЧОЙБАЛСАН СУМ

ЧОЙБАЛСАН СУМ

1. Төрийн бодлогын хүрээнд

- 1.1 Төрийн албан хаагчийн сургалт хөгжил, нийгмийн баталгааг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 1.2 Төрийн үйлчилгээний төрөл, хэлбэрийг шинэчлэн нэмэгдүүлж, төрийн албан хаагчдын ажлын ур чадварт тавигдах шаардлагыг өндөржүүлэн иргэдэд хүргэх төрийн үйлчилгээний чанарыг сайжруулна.
- 1.3 Багийн хөгжлийг дэмжих хөтөлбөр 2 –ыг хэрэгжүүлнэ.
- 1.4 Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг ханган ажиллаж, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлж ажиллана.
- 1.5 Иргэд, олон нийт, төрийн албан хаагчдад эрх зүйн боловсрол олгоно.
- 1.6 Төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах, тэдний үйл ажиллагааг бодлогоор дэмжинэ.

2.1 Нийгмийн бодлогын хүрээнд

- 2.1.1 Аймаг болон Хавирга хилийн боомттой хатуу хучилттай автозамаар холбогдоно.
- 2.1.2 Сумын төвд 2.5 км хатуу хучилттай авто зам тавина.
- 2.1.3 Сургуулийн хуучин барилгыг засварлаж ахуйн үйлчилгээний төв байгуулна.
- 2.1.4 Нэгдсэн халаалт, цэвэр бохир усны байгууламж барина.
- 2.1.5 Иргэдийг хямд, орчин үеийн шийдэл бүхий орон сууцжуулах хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 2.1.6 Сумын төвийн гудамж бүрийг бүрэн гэрэлтүүлнэ.
- 2.1.7 “Жишиг” гудамж төслийг хэрэгжүүлнэ.
- 2.1.8 Хавирга хилийн боомт болон сумын төвд ариун цэврийн байгууламж барина.
- 2.1.9 Монгол Улсын хошой баатар, маршал Хорлоогийн Чойбалсангийн төрсөн газарт “Хүндэтгэлийн цогцолбор” барина.

2.2 Эрүүл мэндийн чиглэлээр

- 2.2.1 Эрүүл мэндийн төвийг /ЭХО аппарат/-аар хангана.
- 2.2.2 Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг нэмэгдүүлж, өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг болон дэд хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж ажиллана.
- 2.2.3 Ахмад настан, хүүхдийг эмчлүүлэх таатай орчин нөхцлийг бүрдүүлэхийн зэрэгцээ хүн эмнэлгийг түшиглэн суурь өвчтэй болон ахмад-хүүхдийг сувиалан эрүүлжүүлэх сувилал ажиллуулна.

2.2.4 Эрүүл шүд-эрүүл хүүхэд хөтөлбөрийг дэмжин ажиллана.

2.2.5 Эрүүл мэндийн төвийн барилгад өргөтгөл хийнэ.

2.3 Боловсрол, Соёл урлаг, спортын чиглэлээр

2.3.1 Спорт заал шинээр барина.

2.3.2 Биеийн тамир, спортыг хөгжүүлэх үндсэний хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

2.3.3 Аймгийн "Үндэсний бөхийг хөгжүүлэх" дэд хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

2.3.4 "Маршал" оюутны сургалтын тэтгэлэгт хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

2.3.5 Орон нутгийн судлах танхимыг тохижуулж, өргөжүүлнэ.

2.3.6 Сургуульд ариун цэврийн байгууламж барина.

3. Хөдөө аж ахуйн хөгжлийн хүрээнд

3.1 Бүх багуудад малчдын санал, хүсэлт, иргэдийн оролцоонд тулгуурлан гүний худгуудыг гаргаж, бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлнэ.

3.2 Малжуулах төсөл хэрэгжүүлнэ.

3.3 Хөдөө аж ахуйн хоршоо, фермерийн аж ахуйг эрчимтэй хөгжүүлэх, эдийн засаг эрх зүйн нэн таатай орчныг бүрдүүлж дэмжинэ.

3.4 "Органик" хөдөө аж ахуйг хөгжүүлэх төмс, хүнсний ногооны тариалалтыг нэмэгдүүлэх иргэдийг бодлогоор дэмжиж "Хүлэмжийн аж ахуй" байгуулах төслийг хэрэгжүүлнэ.

3.5 Малын үүлдвэр угсааг сайжруулах, эрчимжсэн аж ахуйг хөгжүүлэх үйл ажиллагааг бодлогоор дэмжинэ.

3.6 Мал эрүүлжүүлэх, мал эмнэлгийн үйл ажиллагааг сайжруулах ажлыг аж ахуй нэгжүүдтэй хамтран хэрэгжүүлнэ.

3.7 Арьс, шир боловсруулах цехийг байгуулж ажлын байрыг нэмэгдүүлнэ.

3.8 Сүү боловсруулах жижиг дунд үйлдвэрийг байгуулна.


3.9 Бэлчээрийн менежментийг сайжруулна.

4. Эдийн засгийн хөгжлийн бодлогын хүрээнд

4.1 "Жижиг дунд үйлдэрлэлийг орон нутгийн онцлогт тохируулан хөгжүүлж нутгийн брэндийг бий болгоно.

4.2 Хүн, амын хөдөлмөр эрхлэлтийг дэмжин орлогыг тогтвортой нэмэгдүүлж, жижиг дунд бизнесыг өрх, гэр бүлд нэмэгдүүлэх бодлогыг дэмжинэ.

4.3 Газрын нөөц боломжинд тулгуурлаж атар болон атаршсан талбайг сэргээж газар тариалангийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.



5. Байгаль орчин, ногоон хөгжлийн хүрээнд

5.1 Хөх нуур, Сүмийн цагаан нуурт аялал жуулчлалын бүс байгуулна.

5.2 Хадлангийн талбайг зөв зохистой ашиглах бодлого боловсруулах, иргэн, аж ахуй нэгжийг дэмжих замаар хадлан бэлтгэлийг нэмэгдүүлж экспортолно.

5.3 Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын үйл ажиллагаанд иргэдийн оролцоотойгоор хяналт тавих, нөхөн сэргээлтийг эрчимжүүлж бүрэн гүйцэтгүүлж хүлээн авна.

5.4 Газар зохион байгуулалтын төлөвлөгөөг цахим системд оруулж газрын нэгдсэн санд нэгтгэнэ.

5.5 Ой хээр, ахуйн гал түймрээс урьдчилан сэргийлэх сургалт, дадлагыг зохион байгуулна.

5.6 Маршалын цэцэрлэгт хүрээлэнг өргөжүүлэн тохижуулж, ногоон байгууламжийг нэмэгдүүлнэ.

**ЧОЙБАЛСАН СУМЫН МОНГОЛ АРДЫН
НАМЫН ХОРОО**